№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	150ZJ-I-A58	
2	Дамрын эргэлтийн хурд, эрг/мин	490-980	
3	Хүчин чадал, м³/цаг	131-532	
4	Материал шахах өндөр, м	13.7-59.3	
5	Суурилагдсан чадал, кВт	132	
6	Хэрэглэгдэх тоо, шир	1	

Хүснэгт 27. Булингын насосны техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	100ZJ-A42	
2	Дамрын эргэлтийн хурд, эрг/мин	700	
3	Хүчин чадал, м³/цаг	66	
4	Материал шахах өндөр, м	15-70.8	
5	Суурилагдсан чадал, кВт	22	
6	Хэрэглэгдэх тоо, шир	2	

Хүснэгт 28. Булингын насосны техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	300ZJ-A95	
2	Дамрын эргэлтийн хурд, эрг/мин	590	
3	Урсгалын хурд, м³/цаг	440	
4	Материал шахах өндөр, м	58.8	
5	Суурилагдсан чадал, кВт	400	
6	Хэрэглэгдэх тоо, шир	2	

Хүснэгт 29. Булингын насосны техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	100ZJ-A39	
2	Дамрын эргэлтийн хурд, эрг/мин	1480	
3	Урсгалын хурд, м³/цаг	255	
4	Материал шахах өндөр, м	61	
5	Суурилагдсан чадал, кВт	75	
6	Хэрэглэгдэх тоо, шир	2	

Хүснэгт 30. Эргэлтийн усны насосны техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	2PNJ	
2	Дамрын эргэлтийн хурд, эрг/мин	1450	
3	Урсгалын хурд, м³/цаг	27-50	
4	Материал шахах өндөр, м	19-22	
5	Суурилагдсан чадал, кВт	7.5	
6	Хэрэглэгдэх тоо, шир	11	

Хүснэгт 31. Эргэлтийн усны насосны техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	TS-80	
2	Дамрын эргэлтийн хурд, эрг/мин	1450	
3	Урсгалын хурд, м³/цаг	13.6-60	
4	Материал шахах өндөр, м	3.6-128	
5	Суурилагдсан чадал, кВт	11	
6	Хэрэглэгдэх тоо, шир	4	

Хүснэгт 32. Цахилгаан өргүүрийн техникийн үзүүлэлт

Цехийн нэр	Марк	Хүчин чадал, тн	Үзүүлэлт	Цахилгаан зарцуулалт, кВт	Тоо, ш
Нунтаглан ангилах хэсэг	LDA-20	20	L=25.5м, H=18/24м	83.2	1
Хөвүүлэн баяжуулах хэсэг	LDA-10	10	L=13.5м, H=12м	12.1	1
Засвар механикийн хэсэг	LDA-2	2	L=10.5м, H=12м	7.2	1
Шүүх, өтгөрүүлэх хэсэг	LDA-3	3	L=26.5м, H=12м	8.8	1
Баяжмал савлах, хадгалах хэсэг	LDA-3	3	L=12м, H=8м	7.0	1

Хүснэгт 33. Утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоон үзүүлэлт
	Тоног төхөөрөмжийн марк	SEM 650B
1	Утгуурын багтаамж, м ³	3
2	Эргэлтийн радиус, м	6.1
3	Ачих хамгийн их өндөр, м	3.1
4	Явах ангийн урт, м	6.3
5	Явах ангийн өргөн, м	2.7
6	Их биеийн өндөр, м	3.5
7	Түлш зарцуулалт, л/цаг	18
8	Хэрэглэгдэх тоо	2



1.6. Баяжуулах үйлдвэрийн дэд бүтэц, барилга байгууламж

1.6.1. Ус хангамж

Баяжуулах үйлдвэр нь өөрийн талбай дээр нийт 16.2 л/с ундаргатай 3 худаг гаргаж уурхайн болон баяжуулах үйлдвэрийн цэвэр усны хэрэгцээг хангасан байна. Баяжуулах үйлдвэрийн жилийн цэвэр усны хэрэгцээ 51070 м³ буюу 3.03 л/с байх ба ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд байрлах 3 худаг нь үйлдвэрийн цэвэр усны хэрэгцээг бүрэн хангаж байна.

Үйлдвэрийн технологийн усны хэрэгцээ хоногт дунджаар 2200.1 м³ түүхий ус шаардлагатайг үйлдвэрийн усны балансын тооцоогоор тогтоосон ба баяжуулах үйлдвэр нь ашиглагдсан усныхаа 84.3%-ийг эргүүлэн ашиглах ба үйлдвэрийн шинэ усны хэрэгцээ хоногт 261.49 м³ байна.

Ахуйн хэрэгцээний тооцоо: Нэг хүний хоногийн ахуйн хэрэгцээний ус 80 л/хоног байхаар тооцож хийсэн. Энэ нь усны хэрэглээний хамгийн их байх үеийн тооцоо болно. Баяжуулах үйлдвэрийн нэг дор байрлах ажилчдын тоо нь үйлдвэрийн ажилчид болон удирдах албан тушаалтнууд нийтдээ 45 хүн байрлан ажиллахаар тусгасан. Ахуйн хэрэглээний хоногийн усны хэмжээ нийт 6.56 м³ байх тооцоотой байна.

1.6.2. Баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамж

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамжийг Батноровын дэд станцаас 35кВ-ын шугам татаж хангасан байна. Өндөр хүчдэлийн шугамын нийт трассын урт 11 км үүнээс 0.45км нь кабель шугам байна.

Үйлдвэрлэлийн талбайд цахилгаан хэрэглэгч объектууд нь баяжуулах үйлдвэр, үйлдвэрийн оффис, үйлдвэрийн ажилчдын кемп, засвар механикийн цех, ШТС зэрэг байна. Баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангахын тулд бие биеэсээ үл хамаарах 2 хүчний трансформатор бүхий ЕБДС-ын схемийг сонгов.

1.6.3. Хаягдлын аж ахуй

Баяжуулах үйлдвэр барьж байгуулахаар төлөвлөсөн газар нь тэгш тал гадаргуу болно. Хаягдлын аж ахуйг бүс нутгийн салхины зүг чиг болон газрын гадаргын нам дор газрыг ашиглан байгуулахад зохимжтой байдаг. Баяжуулах үйлдвэрээс гарах шингэн хаягдлыг усгүйжүүлэн хатуу кек байдлаар гадаад овоолго үүсгэн хадгалах нь зохимжтой ба цаашид хатуу хаягдлыг бүрэн ашиглаж баяжуулан зам болон барилгын тоосго үйлдвэрлэлд ашиглах боломжтой юм.

Баяжуулах үйлдвэрийн хаягдлыг үйлдвэрийнхээ зүүн урд хэсэгт байгуулахаар төлөвлөсөн ба үйлдвэрээс 0.3 км-т $V=77739.6 \text{ м}^3$ эзлэхүүнтэй хуурай хаягдлын даланг зохион байгуулна. Хаягдлыг овоолгод захилах хэлбэрийн овоолгоор овоолох ба байгаль орчин нөлөөлөх сөрөг нөлөөтэй тоосжилтыг бууруулахад анхаарах шаардлагатай.

Хаягдлын аж ахуй нь нийт 77739.6 м^3 хатуу хаягдлыг агуулж байх ба ойролцоогоор 7500 м^2 талбай эзлэх ба баяжуулах үйлдвэрийн зүүн урд хэсэгт төлөвлөсөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Физик, газар зүй

Тус талбай нь мужлалын хувьд хээрийн бүсэд хамаарагдах боловч говийн бүс рүү шилжих хэсэг дээр байрладаг. Гадаргуу нь намхан уул, гүвээ толгодорхог, хэрчигдэл багатай, өргөн хөндий хоолой хослосон онцлогтой. Үнэмлэхүй өндөр нь 1040.0 м (Хуучин Хар-Айраг сумын төв)-өөс 1313 м (Их Хонгор Овоо)-т хэлбэлздэг. Уг дүүргийн харьцангуй өндөршилт нь 1015-1070 м байдаг.

Энэхүү талбай нь 1110-1130 м-ийн үнэмлэхүй өндөрт байрладаг. Талбайн усан хагалбар болох намхан уулс, гүвээ нь өргөргийн дагуу чиглэлтэй урт, нарийн сунасан тогтоцтой бөгөөд энэ нь тухайн дүүргийн тектоник эвдрэлийн чигтэй давхцдаг. Чулуулгийн илэрц маш муу харин талбайн баруун, хойд талаар рифейн хувирмал чулуулаг болон пермийн гүний чулуулгийн гаршууд сайтар илэрдэг бөгөөд бусад газарт дээрх насны чулуулгаас тогтсон жижиг толгод, гүвээнүүдийн орой хэсгээр гарш сайтай байдаг.

2.2. Усан сүлжээ

Тухайн дүүрэгт тогтмол урсгалтай гол горхи байдаггүй, харин цас хайлах үеэр юмуу хүчтэй, үргэлжилсэн борооны үед түр зуурын урсгалтай горхи хөндий, амууд даган урсдаг ба олон тооны жижиг нуурууд үүсдэг боловч тэдгээр нь хурдан зуур тогтоод ширэгдэг.

Талбайн ойролцоо 10 гаруй гар худаг байдаг тэдгээрийн нөөц нь тус бүр бага бөгөөд шавхалтын дараа 4-6 цагийн хугацаанд нөхөгддөг. Худгуудын усны ихэнх нь давсархаг, ундны усанд тохиромжгүй, тэдгээрээс цөөн хэсэг нь хүн амын ахуйн хэрэгцээнд ашиглагддаг.

Айраг сумын төвд өрөмдмөл гүний худаг байдаг ба усны чанар сайн ундарга сайтай тул энэ дүүргийн ахуйн хэрэгцээний усны эх үүсвэр болдог.

2.3. Уур амьсгал

Дүүргийн цаг уур эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн болон хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, жилийн дундаж хэм нь -2°C . Хамгийн хүйтэн цаг нь 12-р сараас 2-р сарын эхэн байдаг ба -28.5°C -ээс -32.9°C хүртэл хүйтэрдэг бөгөөд хамгийн халуун сар нь 7-8-р сар, $+23^{\circ}\text{C}$ -ээс $+33^{\circ}\text{C}$ -ийн дулаантай байдаг.

Жилийн хур тунадасны хэмжээ 101-343 мм-т хэлбэлздэг ба улирал бүрд харилцан адилгүй буудаг. Үүний 70-85 % нь зуны улиралд бороо хэлбэрээр буудаг. Өвөлд 10-20 мм-ээс хэтрэхгүй цас ордог, цасан бүрхэвчийн зузаан 5-8 см боловч дараа жилийн өвөлд цас ороогүй тохиолдол цөөнгүй тохиолддог. Анхны цас 10-11 сарын үед ордог ба 3-р сард хайлж дуусдаг.

Агаарын чийгшилт зундаа 46-68 %, харин өвөлдөө 60-85 %-д хэлбэлздэг. Өвөлдөө хүйтэн боловч хур тунадасгүй нарлаг цаг агаар зонхилдог, хавартаа мөн адил боловч салхи шуурга ихтэй байдаг. Хүйтний улиралд хөрсний хөлдөлт гадаргуугаас дунджаар 2-2.5 м, олон жилийн

цэвдэг байхгүй. Хавар цагт бараг тогтмол салхи шуургатай байдаг ба салхины хурд дунджаар 4.7 м/с гэх боловч зарим үед 14-18 м/с, үе үе 20-24 м/с хүрч хүчтэй цасан болон шороон шуурга тавьдаг. Салхины чиглэл голдуу баруун хойноос зүүн урагш чиглэлтэй байдаг.

Зуны ихэнх нь аагим халуун, харин сүүл рүү бага зэрэг сэрүүсч, бороо хур элбэгшдэг. Намартаа сэрүүн салхитай, нарлаг өдрүүд болж, шөнөдөө хасах хэмтэй, өдөртөө дулаан цаг агаар зонхилдог.

2.4. Ургамал, амьтан

Тухайн дүүрэг нь тал хээрийн бүсээс хагас цөлийн бүсийн заагт оршдог, ихэнх хэсэгтээ бор хүрэн, хагас цөлийн хөрстэй, нам дор хэсэг, хөндий цайдмуудаар хужирлаг саарал, шаварлаг хөрс, заримдаа элс зонхилсон байдаг.

Ургамлын бүрхэвч муутай, тачир сийрэг өвстэй, энд тэнд алтан харгана, зэрлэг буйлсын намхан бутнууд ургасан байдаг, хөндий хуурай сайруудын захаар дэрс, цөөн тоогоор шагшуурга ургадаг. Ой мод, сөөг байхгүй.

Амьтны аймаг олон төрөлтэй, араатан амьтдаас чоно, үнэг, хярс, мануул, мэрэгчдээс туулай, цөөн тоогоор тарвага, олон төрөл тооны хулганатай, хэвлээр явагчдаас бамбай толгойт могой, хонин ба могой гүрвэлтэй, жигүүртнээс бүргэд, элээ, тогоруу, харцага, сар, ногтруу, тагтаа, нуур тогтсон үед ангир, нугас, галуу түр байрладаг.

2.5. Нийгэм эдийн засаг

Тухайн дүүрэгт хүн ам сийрэг 1 кв.км талбайд 0.2-0.6 хүн ам ногддог. Хамгийн олон хүнтэй нь Хар-Айраг сум 1500-2000 хүн амтай. Харин өнөөгийн байдлаар зундаа бусад газраас хүмүүс ирж хувиараа жонш олборлодог, эдгээр “хувиараа жонш олборлогчдын” тоо заримдаа 3000-5000 хүрдэг гэсэн мэдээ бий.

Талбай нь Улаанбаатар хотоос зүүн урагш 340 км, Хар Айрагийн төмөр замын өртөөнөөс баруун хойш 26 км зайд байрлана. Талбайн орчмоор цөөн тооны малчин өрхүүд зундаа нүүдэллэн ирдэг, тэдний өвөлжөө нь холгүй, Хөх Өндөр уулын орчмоор байдаг.

Хар Айраг тосгонд эмнэлэг, шуудан холбоо, цахилгаан станц, дэлгүүр хоршоо, зочид буудал, халуун ус зэрэг нийтийн үйлчилгээний газрууд байдаг ба хамгийн том аж ахуйн нэгж нь “Монросцветмет” нэгдлийн үйлдвэрлэлийн бааз, ачилтын талбай, механик засварын газар зэрэг үйлдвэрийн газрууд байдаг. Хүн амын нилээд нь тэдний буюу төмөр замын ажилчид байдаг, цөөн үлдсэн хэсэг нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг.

Талбай нь Улаанбаатар хоттой засмал замаар холбогддог. Эдгээр замуудаар жилийн аль ч улиралд ямарч тээврийн хэрэгсэл саадгүй зорчих боломжтой

1950-аад оноос эхлэн тухайн бүс нутагт ордуудад ил, далд аргаар олборлох үйл ажиллагаа явагдсан.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

“ЛАКВЭСТ” ХХК-ийн “Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр” төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга БОНХЯ-аас /хуучин нэрээр/ гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

3.2. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 34. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулаг	Богино хугацааны	Урт хугацааны	Будаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	x				x		x	x		
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x			x		x			x
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Эрдэс түүхий эдийн нөөц		x			x		x			x
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ		x			x		x		x	
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x				x		x	x		
Хөрсний эвдрэл, бохирдол		x			x		x		x	
4. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			x
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x	x		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			x
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x		x			x
5. Бусад нөлөөлөл										
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x		x	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x			x			x

Хүчтэй салхи, уруйн үер										
Дүн	9	4		1	12		13	3	3	7

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, бага зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна.

Үүнд:

1. Агаарын чанарын өөрчлөлт
2. Бичил уур амьсгалын өөрчлөлт
3. Агаарын бохирдол
4. Хөрсний элэгдэл, бохирдол
5. Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
6. Орон нутгийн орлого нэмэгдэх
7. Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
8. Ажлын байр нэмэгдэх
9. Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
10. Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
11. Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
12. Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд үйлдвэрийн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, төсөлтэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 35. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	х			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох			х	
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				

Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				x
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			x	
Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				x
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх			x	
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		x		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		x		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				x
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			x	
4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			x	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			x	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			x	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		x		
5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				x

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Хүснэгт 36. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Агаар	Хайлуур жоншны хүдрийг тээвэрлэх, баяжуулах үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед тоос, тээврийн хэрэгслээс гарах ШТМ-ын утаа агаарт дэгдэж сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
2	Хүний эрүүл мэнд	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлаагүйгээс үйлдвэрийн осол гэмтэл гарах, агаар, хөрс, усан орчин бохирдсоноос хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 37. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин				
Тоосжилт үүсэх	Зам талбай болон бусад тоосжилт үүсч болзошгүй гадаргууг услах	7-9-р сард	2 500.0	Агаарын тухай хууль MNS 4585:2025 MNS 4990:2023 MNS 4598:2025
	Баяжуулах үйлдвэрээс гарах тоосжилтыг багасгах зорилгоор тоос үүсэж буй тоног төхөөрөмжүүдэд хаалт суурилуулах.	7-р сард		
	Баяжуулах үйлдвэр, ажилчдын хотхоны байр болон хоорондын зам, талбайг усалж чийглэж байх, агааржуулалтын системийн бүрэн бүтэн байдлыг хянах	7-9-р сард	1 000.0	
	Дотоод тээвэрлэлтийн замд салхины хурд ихтэй үед усалгаа хийж байх.	7-9-р сард	500.0	
Хөрс, ургамал				
Ажилчдын оффис, үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал нь хөрс бохирдуулах	Тээвэрлэлтийн олон салаа зам гарахаас урьдчилан сэргийлж дотоод болон гадаад замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх	7-р сард	1 000.0	MNS 4597 : 2014
Хөрсний бохирдол үүсэх	MNS 5924 : 2015 стандартын дагуу ариун цэврийн байгууламжийг барьж байгуулан ашиглах	7-8-р сард	2 000.0	MNS 5924 : 2015
Бусад асуудлаар				
Сонирхогч талуудын оролцоог хангах	БОМТ болон түүний тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж илгээх	Жилд 1 удаа 10-р сард	-	“Байгаль орчин хамгаалах тухай” хуулийн дагуу
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дүн			7 000.0	

4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 38. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Ногоон байгууламж бий болгох	1000 ш мод тарих	Айраг сумын ЗДТГ-тай хамтран сонгосон талбайд	5 000.0	10-р сард
	Нийт			5 000.0	

4.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Үйлдвэрийн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол үйлдвэрийн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

4.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 39. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал, мян.төг
Химийн бодис болон сав баглаа боодлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Химийн бодис нийлүүлэгч тал зардлыг бүрэн хариуцна
Ажилчдад химийн бодистой хэрхэн харьцах сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	
Ажилчдад химийн бодистой харьцахад шаардлагатай хувцас хэрэгслээр хангах	
Нийт зардал	-

4.5. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 40. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал, мян.төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлын цэг, ангилан ялгах үйлдвэрийн талбай, кемп орчимд бохирдол үүсгэж болзошгүй	Хог хаягдлыг ялгах, зайлуулах, устгах, цэвэршүүлэх менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах	500.0	Сар бүр 5-10-р сард	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу засаж тохижуулах	4 000.0	7-р сард	
	Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хадгалах, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх		9-р сард	
	Нийт	4 500.0		

4.6. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 41. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар				
CO ₂ , NO ₂ , SO ₂ Тоос нийт (PM ₁₀ , PM _{2.5})	Баяжуулах үйлдвэр дотор-1 Үйлдвэрийн хашаан дотор-1 Хүдрийн хаягдал овоолго ойролцоо-1 Хаягдал сан ойролцоо-2 цэг Тээврийн зам дагуу- 1цэг	Жилд 2 удаа, 7 болон 10-р сард	660.0	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн шаардлага. MNS 6768:2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсголыг хамгаалахад тавих ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний хүнд металлууд Хөрсний эрүүл ахуй	Баяжуулах үйлдвэрийн хашаан дотор-1 Хаягдал сан ойролцоо-3 Кемп ойролцоо-1	Жилд 2 удаа 7 болон 10-р сард	500.0	MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. MNS 3297:1991 Хот суурин газрын хөрсний ариун Ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ
Усан орчин				
Хими, Физикийн үзүүлэлт /NH ₄ , NO ₃ , NO ₂ , булинга, pH, өнгө, цахилгаан дамжуулах чанар/ Бичил амь судлал /Нийт нян тоо, E.col/i	Унд ахуйн ус -1 цэг Хаягдал ус-1 цэг Хяналтын 2 цооног ус- 2 цэг	Жилд 2 удаа 7 болон 10-р сард	772.0	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 4943:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн			1 932.0	

ОХШХ-ийн хүрээнд үйлдвэрийн талбай орчмоос агаарын чанарын болон хөрсний бохирдлын дээжийг жил бүр авч шинжлүүлж байна.

4.7. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Үйлдвэрийн талбайд галын аюул гарч болзошгүй тул гал унтраах багаж хэрэгслийн хангамжийг байдлаас шалтгаалан нэмж авах шаардлагатай. Мөн ажилчдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаатай холбоотой анхааруулах самбар тэмдэглэгээг үйлдвэрийн шаардлагатай хэсэгт байршуулах шаардлагатай.

Түүнчлэн ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй төслийн ойролцоох байгууллагуудтай байгаль орчныг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулж, нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллах нь үр дүнтэй юм.

Хүснэгт 42. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал, мян.төг
Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	-
Ус ашиглах гэрээг байгуулж, ус ашигласны төлбөрийг гэрээний дагуу төлөх	-
Хаягдал усны дүгнэлт гаргуулах	-
Галын булан байрлуулах, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгах	1 000.0
Бүх ажилчдыг галын аюулгүй байдлын сургалтанд хамруулах	500.0
Хаягдлын далангийн байгууламжид ажлын байрны үзлэгийг тодорхой давтамжтайгаар явуулах	-
Химийн бодис, хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх арга зэргийг сайтар уншиж танилцаж мөрдөх	-
Болзошгүй ослын үед авах арга хэмжээг тус төслийн удирдлагууд боловсруулж, мөрдөж ажиллах,	-
Нийт зардал	1 500.0

4.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг

хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад

тайлагнах хуваарь

Хүснэгт 43. Олон нийтийн оролцоог хангах, тайлагнах төлөвлөгөө

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
1	Үйлдвэрийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжиж буй талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, холбогдох хүмүүс	Үйлдвэрийн дарга, БО-ны мэргэжилтэн	7-р сард	500.0 мян.төг
2	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, холбогдох хүмүүс	Үйлдвэрийн дарга, БО-ны мэргэжилтэн	10-р сард	500.0 мян.төг

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 16 932.0 мян.төгрөг төлөвлөж өглөө.